



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингалттай дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

"МОНГОЛЫН ИРГЭНИЙ АГААРЫН
ТЭЭВЭР" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.МӨНХТАМИР ТАНАА

2025.03.17 № 07/1095
таний № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлзээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцлон тэмдэглэсэн хэсэг

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр агаарын тээврийн турээсийн AerCap компаниас B787-9 төрлийн онгоц урт хугацааны турээсээр ашиглах гэрээ байгуулж, 2 дахь онгоцоо 2024 оны 4 дүгээр сард хүлээн авч Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 16-д нийцүүлэн тайлагнасан байна.

Гүйцэтгэх захирлын 2024 оны A/407 дугаар тушаалаар Агаарын хөлгийн турээсийн бүртгэлийг СТОУС 16-д нийцүүлэн бүртгэхтэй холбоотой хөрөнгө ашиглах эрхийн элэгдлийн бүртгэлд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 заалт, НББОУС 16-д нийцүүлэн компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан байна.

Асуудлын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 94 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 488 дугаар тогтоолын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, Хөшигтийн хөндийн Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал дахь Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын 53 нэр төрлийн 137,921.7 сая төгрөгийн барилга, байгууламжийг балансаас балансад шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Олон улсын агаарын тээврийн холбооны зорчигч тээвэрлэлтийн ерөнхий дүрмийн 11.6.1 дэх заалт, Гүйцэтгэх захирлын 2018 оны A/543 дугаар тушаалаар баталсан "Ашиглаагүй тийзийн өглөгийг компанийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх журам"-ын дагуу ашиглагдаагүй 2 жилийн хугацаа хэтэрсэн 15,647.5 сая төгрөгийн зорчигч, ачаа тээврийн өглөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь 2024 онд нийт 4,225 нислэг, үүнээс 2,472 хувваарт, 689 орон нутгийн, 870 Ханбумбат чиглэлийн захиалгат, 79 бусад захиалгат, 115 карго нислэгийг үйлдсэн байна. Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласнаар нислэг тээвэрлэлт нэмэгдэж, суудал ашиглалт ёссэн, 2024 онд дундаж суудал ашиглалт 80.0 хувьтай байна гэж тайлagnажээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

З. Н.

Ц.НАРАНЧИМЭГ

АТА9593 96-1109
9023030583

Z:\Yawsan_Bichig\2025\03\17 SNAG-37.Docx